



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон. Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2017. 12. 01 № 15

Асуулга тавих тухай

Монгол Улсад сүүлийн 40 жил тохиолдоогүй халуун хуурайшилттай зун тохиож, нийт нутгаар хур бороогүй, гандуу зуссанаас өвөлжилт хүндрэх эрсдэл үүсээд байна. Өвлийн сар нэгэнт гарч, нийт нутгаар цасан бүрхүүл тогтоод байгаа ч улсын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл 80 гаруй хувьтай байгаа нь хангалтгүй үзүүлэлт гэж үзэж байна.

Иймээс өвлийг өнтэй давах асуудалд шат шатандаа анхаарал хандуулах зайлшгүй шаардлага тулгарч буй тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:


1. Энэ жил улсын хэмжээнд нийт 160.9 мянган малчин өрхөд 66.6 сая мал өвөлжинө. Хөдөө орон нутагт отор нүүдэл хийхэд бэлчээрийн хомсдол бий болж орон нутгийн удирдлага, иргэдийн хооронд өтөг бууц бэлчээрийн холбогдол бүхий маргаантай асуудал үүсч байна. Отроор өвөлжиж, хаваржихад хэрхэн зохицуулалт хийж байгаа вэ. Мөн бэлчээрийн даац өнгөрсөн жилтэй харьцуулахад 3 дахин хэтэрсэн үзүүлэлт гарсан байна. Бэлчээрийн даац жилээс жилд муудаж байгаад цаашид хэрхэн арга хэмжээ авах талаар,
2. Малчдын эрүүл мэндийн асуудалд онцгойлон анхаарч 0-2 насны вакцинд хамрагддаг хүүхэд, жирэмсний болон эмнэлгийн хяналтанд байдаг эх, хүнд өвчтэй хүмүүст онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна. Тухайлбал, 9.8 сая малаа даган өөр аймаг сумын нутагт өвөлжих 100 мянга орчим иргэний эрүүл мэндийн асуудалд хэрхэн анхаарч ажиллах вэ. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, эмийн нөөц, шатахуун гэх мэт шаардлагатай зүйлсийг бэлтгэж, төсвийг шийдвэрлэсэн эсэх талаар,
3. Манай улс жилд 1.2-1.4 сая тонн өвс бэлтгэдэг байсан бол энэ жилийн хувьд 850.0 мянга орчим тонныг бэлтгэж 300-аад мянган тонн өвс дутагдах төлөвтэй байна гэсэн мэдээлэл өгч байна. Малчдын түвшинд өвс, тэжээлийн бэлтгэл 70.1 хувьтай байгаад дүгнэлт хийж хэрхэн шийдвэрлэн ажиллах вэ. Аюулгүйн нөөцийн тэжээл өвсийг хангалттай хувь хэмжээнд бэлтгэсэн үү. Төрийн бодлого, залгамж чанар алдагдах ёсгүй. ХХААХҮ-ийн сайд асан П.Сэргэлэн өнгөрсөн есдүгээр сард Ховд аймагт ажиллан “Малчин, удирдах ажилтны зөвлөгөөн” хийх үеэр “Цагааннуурын боомтоор боодол өвсийг 2500 төгрөгөөр оруулж ирнэ” гэж малчдад хэлсэн. Хэзээ ажил хэрэг болох вэ.

4. Өвөлжилт хүндэрч, хөдөө орон нутаг руу өвс, тэжээл болоод бусад тусламж хүргэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд онцгой байдлын алба, албан хаагчид бэлэн эсэх, тэдний хувцас хэрэглэл, техник тоног төхөөрөмжийн хангалт хэр байгаа талаар,
5. Хөдөө орон нутагт мал, малын гаралтай бүтээгдэхүүн үнэгүйдэж, малчид орлогогүйгээс ядуурлын төвшин нэмэгдэж улсын хэмжээнд 30 хувьд хүрлээ. Банкууд малчны зээлээ зогсоох ба хязгаарлаж олгосны улмаас бэлэн мөнгөний урсгал хомсдож байна. Малчдыг орлоготой болгох, мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар ямар бодлого хэрэгжүүлэн ажиллаж байгаа болон цаашид хэрхэн ажиллах талаар.
6. Хальтиргаа гулгаа үүсч, замын хөдөлгөөнийг хаадаг орон нутгийн зам, давааны арчилгаанд Авто замын засвар, арчилгааны компаниуд бэлэн үү. "Хар цэгүүд"-д өвлийн пост гаргах асуудалд хэрхэн анхаарч байгаа вэ.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хугацаанд ирүүлж, улмаар Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ